



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 179

Улаанбаатар хот

Хорооны 2011 оны 379 дүгээр
тогтоолоор батлагдсан журамд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 379 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн цахим мөнгөний үйлчилгээний журам”-ын 6.7 дахь хэсгийг “Төлөөлөгч нь өдөрт хийх гүйлгээний эрхийн 20 хувьтай тэнцэх хэмжээний баталгаа /барьцаа/-г цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчийн дансанд байршуулсан байна. Төлөөлөгч нь үйлчилгээг эрхлэхдээ цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчтэй байгуулсан гэрээний дагуу олгогдсон кодыг тусгасан орлого, зарлагын баримтыг ашиглана.” гэж өөрчлөн найруулсугай.
2. Мөн журмын 3.13.2 дахь заалтын “...талаарх...” гэсний дараа “Хорооны...” гэж нэмсүгэй.
3. Журмын өөрчлөлтийг оруулж олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН